

**Хоёр дахь шатны хяналтын хүрэн дэх ажлын явцын талаар
ФАТФ-аас хийж буй мэдэгдэл**

Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх түр хороо (ФАТФ) нь яагаад өндөр эрсдэлтэй болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (МУТС)-тэй тэмцэх чиглэлээр хамтран ажилладаггүй улс орнуудад анхаарлаа хандуулж ажилладаг вэ?

МУТС-тэй тэмцэх чиглэлээр гаргасан стандарт, шаардлагуудыг дэлхий нийтээр дагаж мөрдөх үйл ажиллагааг дэмжих зорилгоор өндөр эрсдэлтэй болон ФАТФ-тай хамтран ажилладаггүй улс орнуудаас үүсэх эрсдэл, аюул заналаас урьдчилан сэргийлж, хариу арга хэмжээ авах нь ФАТФ-ын үйл ажиллагааны нэг гол хэсэг юм. Тэдгээр стандартуудыг дэлхий нийтээр дагаж мөрдсөнөөр олон улсын санхүүгийн тогтолцоог хамгаалах, түүнчлэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааг сайжруулах нөхцөл бүрдэх юм. Мөн энэ чиглэлээр хамтран ажилладаггүй, олон улсын стандарт, шаардлагыг дагаж мөрддөггүй улс орнуудыг олон нийтэд мэдээлэх нь тэдгээр улс орнуудад өөрсдийн тогтолцоон дахь стратегийн томоохон дутагдлуудаа олж илрүүлэх замаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо сайжруулах бололцоо олгодог.

ФАТФ-аас олон нийтэд зориулан хэвлүүлсэн баримт бичиг болох *“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны олон улсын түвшин дэх хэрэгжилтийг сайжруулах нь: үргэлжилж буй үйл явц”*-д ФАТФ-тай хамтран боловсруулсан ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлсний үндсэн дээр стратегийн томоохон дутагдлуудаа засах талаар улс төрийн өндөр түвшинд хүсэл зоригоо илэрхийлсэн улс орнуудыг дурдсан байна. Улс орон бүрийн нөхцөл байдал ялгаатай тул тэдгээрийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн цар хүрээ нь ч харилцан адилгүй юм. ФАТФ-ын зүгээс гишүүн орнууддаа дээрх баримт бичигт тодорхойлогдсон стратегийн томоохон дутагдлууд дээр анхаарч ажиллах талаар дэмжлэг үзүүлж байна. Дээрх баримт бичигт 2011 оны 10 дугаар сарын байдлаар Алжир, Ангол, Антигуа ба Барбуда, Аргентин, Бангладеш, Бруней Даруссалам, Камбож, Эквадор, Гана, Гондурас, Индонези, Киргизстан, Монгол, Морокко, Намиби, Непал, Никарагуа, Пакистан, Парагвай, Филиппин, Судан, Танзани, Тажикистан, Тайланд, Туркменистан, Тринидад ба Тобаго, Венесуэл, Вьетнам, Иемен болон Зимбабве гэсэн улс орнууд орсон болно.

Парис, 2011 оны 10 дугаар сарын 28 – Улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандартын хэрэгжилтэд тавих байнгын үнэлгээний ажлын хүрээнд ФАТФ стратегийн томоохон дутагдалтай улс орнуудыг тодорхойлсон бөгөөд тэдгээр улсууд ФАТФ-тай хамтран ажлын төлөвлөгөө боловсруулсан. Улс орон бүрийн хувьд нөхцөл байдал харилцан адилгүй байгаа боловч дутагдлуудаа засах, ахиц дэвшил гаргах талаар улс төрийн өндөр түвшний хүсэл зоригоо бичгээр илэрхийлсэн билээ. ФАТФ эдгээр улс орнуудын хүсэл зоригийг талархан хүлээн авч байна.

Түүнээс гадна ФАТФ-ын үнэлгээнд хамрагдаагүй олон улс орнууд байгаа бөгөөд ФАТФ-ын зүгээс олон улсын санхүүгийн тогтолцоонд эрсдэл учруулж буй бусад орнуудыг тодорхойлох чиглэлээр тогтмол анхаарч ажиллаж байна. ФАТФ энэхүү үйл ажиллагааны хүрээнд зарим улс орнуудад анхан шатны хяналтыг нэмэлт байдлаар хийж эхэлсэн бөгөөд үр дүнг дараа жил танилцуулах юм.

ФАТФ болон ФАТФ-ын бүс нутаг хариуцсан байгууллагууд /FSRBs/ нь дээр дурдсан баримт бичигт орсон улс орнуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, тодорхойлогдсон дутагдлуудыг засах чиглэлээр гаргаж буй ахиц дэвшлийн талаар тогтмол мэдээлж байх болно. ФАТФ эдгээр улс орнуудад ажлын төлөвлөгөөгөө товлосон хугацаанд бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийг уриалж байгаа юм. ФАТФ нь ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд байнга хяналт тавих бөгөөд гишүүн орнуудаас дор дурдсан мэдээлэлд анхаарлаа хандуулахыг хүсч байна.

Монгол Улс

Монгол Улсын хувьд 2011 оны 6 дугаар сард мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоон дахь стратегийн дутагдлуудаа засах чиглэлээр ФАТФ болон Ази номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлэг (APG)-тэй хамтран ажиллах талаар улс төрийн өндөр түвшний хүсэл зоригоо илэрхийлсэн билээ. ФАТФ-ын зүгээс тус улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоон дахь стратегийн дутагдлууд байсаар байна гэж дүгнэж байгаа. Иймд Монгол Улс эдгээр дутагдлуудыг засах, ахиц дэвшил гаргах хүрээнд ажлын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн дүүрэн авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд дараах зүйлс багтана: (1) мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийг гэмт хэрэгт бүрэн тооцдог болох (Зөвлөмж 1 ба Тусгай зөвлөмж II); (2) террорист үйл ажиллагаатай холбоотой эд хөрөнгийг илрүүлэх, тодорхойлох болон битүүмжлэх тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх (Тусгай зөвлөмж III); (3) мөнгө угаахтай холбоотой хөрөнгө мөнгийг хураан авах тогтолцоо бий болгох (Зөвлөмж 3); (4) сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тавигдах шаардлагуудыг өргөжүүлж, тодорхойлох (Зөвлөмж 13 ба Тусгай зөвлөмж IV); (5) Санхүүгийн мэдээллийн албаны Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх чадавхи, нөөц бололцоог нэмэгдүүлэх (Зөвлөмж 26); (6) мөнгөн гуйвуулга, шилжүүлгийн үйлчилгээ эрхлэгч нарын үйл ажиллагааг зохицуулалтад оруулж, журамлах.

ФАТФ-ын зүгээс Монгол Улсыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоон дахь дутагдалтай, сул талуудаа засаж сайжруулахад анхааран, ажлын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэхийг хөхүүлэн дэмжиж байна.